

Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсад телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Засгийн газрын 2010 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл”-д нийцүүлэн гаргасан энэхүү ерөнхий нөхцөл шаардлагаар зохицуулна.

1.2 Телевиз, радиогийн зах зээлд шударга өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) Харилцаа холбооны тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан чиг, үүрэг, бүрэн эрхийн хүрээнд энэхүү ерөнхий нөхцөл шаардлага болон холбогдох бусад журмаар хэрэгжүүлнэ.

1.3 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын зорилго нь Монгол Улсад телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, зах зээлийн өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэх, нийтийн ашиг сонирхолд нийцсэн, чанартай үйлчилгээгээр олон нийтийг хүртээмжтэй хангахад чиглэсэн харилцааг зохицуулахад оршино.

1.4 Олон нийтийн радио, телевизтэй холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрөөр заасан бол уг хуулийг баримтлана.

1.5 “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.2.2-т заасан чиглэлийг баримтална.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагад хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 2.1.1 **“өргөн нэвтрүүлэг”** (broadcasting) гэж агуулгыг нэг цэгээс хэрэглэгчдэд түүнийг дамжуулж байгаа орчин, технологиос үл хамааран нэгэн зэрэг хүргэх үйлчилгээг;
- 2.1.2 **“телевиз”** гэж хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн хөдөлгөөнт дүрс, график, үг, дуутай агуулгыг радио давтамж ашиглан нэвтрүүлэх өргөн нэвтрүүлгийн систем, үйлчилгээ эсхүл үйлчилгээ эрхлэгчийг;
- 2.1.3 **“олон нийтийн телевиз”** гэж Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн дагуу байгуулагдсан ашгийн төлөө бус телевизийн үйлчилгээ эрхлэгчийг;

- 2.1.4 “**арилжааны телевиз**” гэж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай, ашгийн төлөө телевизийн үйлчилгээ эрхлэгчийг;
- 2.1.5 “**кабелийн суваг**” гэж хөдөлгөөнт дүрс, график, үг, дуутай агуулгыг хөтөлбөрийн дагуу бэлтгэж, олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байгаа, тодорхой агуулгын чиглэлээр төрөлжсөн эсхүл төлбөрт сувгийн үйлчилгээ эрхлэгчийг;
- 2.1.6 “**радио**” гэж хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн үг, дуутай агуулгыг радио давтамж ашиглан нэвтрүүлэх өргөн нэвтрүүлгийн систем, үйлчилгээ эсхүл үйлчилгээ эрхлэгчийг;
- 2.1.7 “**телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгч**” (“олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгч” гэдгийг цаашид “ОСДҮЭ” гэх) утастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр телевиз, радиогийн олон суваг болон бусад нэмэлт агуулгыг хэрэглэгчдэд дамжуулан хүргэх үйлчилгээ эрхлэгчийг; /Үүнд кабелийн телевиз, АйПиТВ, МобайлТВ, сансрын хиймэл дагуул ашигласан болон бусад технологи ашигласан телевизийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчид хамаарна/
- 2.1.8 “**агуулга**” гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй тэмдэгт, дохио, текст, зураг, график, дуу, авиа, хөдөлгөөнт дүрс болон бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасан бүтээлийг;
- 2.1.9 “**нэвтрүүлэг**” гэж радио, телевиз эсхүл кабелийн сувгаар дамжуулах зориулалтаар бэлтгэсэн бүх төрлийн агуулгыг;
- 2.1.10 “**хөтөлбөр**” гэж бүх төрлийн нэвтрүүлгийг радио, телевиз эсхүл кабелийн сувгаар дамжуулахаар хуваарьт оруулсныг.

Гурав. Тусгай зөвшөөрөл

- 3.1 Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн Зохицуулах хорооноос баталсан нөхцөл шаардлага, холбогдох журмын дагуу олгоно.
- 3.2 Тусгай зөвшөөрлийг олгохдоо дараахь зарчмыг баримтлана:
 - 3.2.1 тухайн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгааны дүгнэлтэд үндэслэх;
 - 3.2.2 аливаа нөлөөллөөс үл хамаарах, ил тод, шударга байх;
 - 3.2.3 ялгаваргүй арга замаар олгох.
- 3.3 Телевиз, радиогийн тусгай зөвшөөрлийг дараахь төрлөөр олгоно:
 - 3.3.1 олон нийтийн;
 - 3.3.2 арилжааны.
- 3.4 Телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь төрлөөр олгоно:
 - 3.4.1 кабелийн;
 - 3.4.2 хиймэл дагуулын;
 - 3.4.3 АйПиТВ (IPTV);
 - 3.4.4 Мобайл ТВ (Mobile TV).
- 3.5 Радио, телевизийн газрын дахин дамжуулах сүлжээ байгуулахад тусгай зөвшөөрөл олгоно.
- 3.6 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 2.1.5-д тодорхойлсон “кабелийн суваг” –д тусгай зөвшөөрөл олгоно.
- 3.7 Тусгай зөвшөөрлийг зах зээлийн хамрах хүрээгээр нь дараахь төрөлд хуваана:

- 3.7.1 Улаанбаатар хот;
- 3.7.2 аймгийн төв, сум, алслагдсан дүүрэг;
- 3.7.3 Монгол Улсын нутаг дэвсгэрт орон даяар.
- 3.8 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 3.7.3-д заасан төрлийн тусгай зөвшөөрлийг Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс сонгон шалгаруулж олгоно.
- 3.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлага, үндсэн үйл ажиллагаа, удирдлага, хөтөлбөртэй холбоотой харилцаагаа бусдад шилжүүлэхийг хориглоно.

Дөрөв. Эзэмшлийн ил тод байдал

- 4.1 Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор эзэмшлийг олон нийтэд ил тод болгохын тулд хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, удирдлагын талаар дараахь мэдээллийг Зохицуулах хороонд ирүүлнэ:
 - 4.1.1 Эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээ (гадаад улсын хөрөнгө оруулалттай бол аль улсынх болохыг тодорхой заана);
 - 4.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас;
 - 4.1.3 Хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын нэр, иргэншил.
- 4.2 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4.1-д заасан мэдээллийг жил бүрийн 1 дүгээр сард, өөрчлөлт орсон бол өөрчлөлт орсноос хойш 1 сарын дотор Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэнэ.
- 4.3 Эзэмшлийн ил тод байдлын талаарх мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ.

Тав. Хөтөлбөрийн агуулгад тавигдах шаардлага

- 5.1 Телевиз, радио, кабелийн суваг нь хөтөлбөрөө бэлтгэхдээ олон нийтийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх чиглэлийг үндсэн үүрэг, зорилгоо болгон үзэгч, олон нийтийн эрх ашгийг дээдэлнэ.
- 5.2 Телевиз, радио, кабелийн суваг нь хөтөлбөрөө Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон энэхүү ерөнхий нөхцөл шаардлагад бүрэн нийцүүлж, хариуцлага хүлээнэ.
- 5.3 Монгол Улсын холбогдох хуулийг зөрчсөн нэвтрүүлэг болон зар сурталчилгаа бүтээх, түгээхийг хориглоно. Үүнд:
 - 5.3.1 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12.1, 12.2, 20.1, 21.1, 22.1, 25.1–д заасныг зөрчиж, зохиогч эсхүл эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг нь ашигласан;
 - 5.3.2 Зар сурталчилгааны тухай хуулийн 6.5, 7-р зүйл, 13.4, 13.6, 13.8, 14-р зүйл, 16-р зүйл, 17.2-д заасан зар сурталчилгаа бүтээсэн, түгээсэн;
 - 5.3.3 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.6-ийн дагуу хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлсэн;
 - 5.3.4 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5-д заасан зүйлсийг илэрхийлсэн;
 - 5.3.5 Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 7 дугаар зүйлийн 7.2.3, Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлд заасан эротик төрлийн контентийг агуулсан, садар самууныг илэрхийлсэн;

- 5.3.6 Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан согтууруулах ундаа сурталчилсан;
 - 5.3.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасан зүйлсийг сурталчилсан, илэрхийлсэн;
 - 5.3.8 Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд заасан үндэсний эв нэгдлийг бусниулах чиглэлээр сурталчилгаа явуулсан;
 - 5.3.9 Эрүүгийн хуулийн 178³ дугаар зүйлд заасан терроризмийг сурталчилсан;
 - 5.3.10 Эрүүгийн хуулийн 179 дугаар зүйлд заасан нийтийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан;
 - 5.3.11 Эрүүгийн хуулийн 144 дугаар зүйлд заасан шашны харгис үзэл номлолыг сурталчилсан;
 - 5.3.12 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-д заасан зүйлсийг илэрхийлсэн.
- 5.4 Долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50 хувиас доошгүй нь Монгол Улсад бүтээгдсэн эсхүл Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бүтээсэн нэвтрүүлэг байна. Энэхүү хувийг тооцохдоо дараахь нэвтрүүлгийг багтааж оруулна:
- 5.4.1 Монгол үндэсний эрх ашиг, соёл, хэл, зан заншлыг сурталчилсан, таниулсан эсхүл хүүхдэд зориулсан гадаад нэвтрүүлгийг монгол хэл дээр орчуулсан нэвтрүүлэг;
 - 5.4.2 Тив, дэлхийн хэмжээний спорт, урлагийн арга хэмжээг албан ёсны эрхтэйгээр дамжуулж байгаа шууд нэвтрүүлэг;
 - 5.4.3 Нэвтрүүлгийн давталт.
- 5.5 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5.4-д заасан хувийг тооцохдоо монгол хэл дээр орчуулсан гадаад киног тооцохгүй.
- 5.6 Гамшгийн болон онцгой байдал үүссэн нөхцөлд эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журмын дагуу шаардлагатай зар, мэдээллийг нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ.
- 5.7 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Орон нутгийн сонгуулийн тухай хуулиудыг дагаж мөрдөн сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэг хүлээнэ.
- 5.8 Телевиз, радио, кабелийн суваг нь нэвтрүүлгээ 2 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална.

Зургаа. Телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүрэг, хариуцлага

Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь дараахь үүрэг, хариуцлагыг хүлээж ажиллана:

- 6.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5 дугаар бүлэгт тодорхойлсон хөтөлбөрийн агуулгад тавигдах шаардлагуудыг хангаж ажиллана.
- 6.2 Нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг, тэмдэглэгээг стандартад заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлнэ. Олон нийтэд нэвтрүүлгийн насны ангилалын тэмдэг, тэмдэглэгээг сурталчилж, таниулна.
- 6.3 Үзэгчээс ирүүлсэн чат, мессежийн агуулгыг зурагтын дэлгэц дээр шууд харуулахгүй. Урьдчилан тодорхойлсон агуулгын дагуу телевиз өөрөө зохион байгуулан мессежээр санал асуулга, судалгаа авах нь нээлттэй байна.

- 6.4 Нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа нь арван таван минутаас хэтрэхгүй байна.
- 6.5 Зар сурталчилгааны эхлэл болон төгсгөлийг үзэгчдэд ойлгомжтой байдлаар илэрхийлнэ.
- 6.6 Нэвтрүүлэг дундуур баннер хэлбэрийн зар сурталчилгааг стандартад заасны дагуу гаргана.
- 6.7 Телевизийн нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэх, дамжуулах, хэрэглэгчдэд хүргэх техник төхөөрөмж, систем нь техникийн стандартын шаардлагыг хангасан байна.
- 6.8 Зохицуулах хорооноос гаргасан төлөвлөлтийн дагуу тоон технологид шилжинэ.

Долоо. Радиогийн үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүрэг, хариуцлага

Радиогийн үйлчилгээ эрхлэгч нь дараахь үүрэг, хариуцлагыг хүлээж ажиллана:

- 7.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5 дугаар бүлэгт тодорхойлсон нэвтрүүлгийн агуулгад тавигдах шаардлагуудыг хангаж ажиллана.
- 7.2 Нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа нь арван найман минутаас хэтрэхгүй байна.
- 7.3 Зар сурталчилгааны үнийг тогтоохдоо секундийн алхамаар тооцно.
- 7.4 Радиогийн нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэх, дамжуулах техник төхөөрөмж, систем нь техникийн стандартын шаардлагыг хангасан байна.
- 7.5 Зохицуулах хорооноос гаргасан төлөвлөлтийн дагуу тоон технологид шилжинэ.

Найм. Кабелийн сувгийн хүлээх үүрэг, хариуцлага

Кабелийн суваг нь дараахь үүрэг, хариуцлагыг хүлээж ажиллана:

- 8.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5, 6 дугаар бүлэгт тодорхойлогдсон шаардлага болон үүрэг хариуцлагыг хангаж ажиллана.
- 8.2 Нэг хоногийн хөтөлбөрийн цагийн 80 хувиас доошгүй нь төрөлжсөн чиглэлээрээ бэлтгэсэн агуулга байна.
- 8.3 Зурагтын дэлгэц дээр кабелийн суваг, төрөлжсөн чиглэлээ тодорхой байдлаар илэрхийлнэ. Тухайлбал логондоо илэрхийлэх, дэлгэцийн буланд тодорхой хугацаанд бичиж харуулах эсхүл нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд үзүүлэх гэх мэт.

Ес. Телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүрэг, хариуцлага

Телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь дараахь үүрэг, хариуцлагыг хүлээж ажиллана:

- 9.1 Өрсөлдөөний тухай хууль, тогтоомж болон үл ялгаварлах, ил тод байх зарчмыг баримтална.
- 9.2 Сүлжээгээр дамжуулах сувгийн тоо, төрөл, хуваарилалт болон тэдгээрт орох өөрчлөлтийг Зохицуулах хороонд тухай бүр ирүүлж хянуулна.
- 9.3 Бүх ОСДҮЭ-д нь Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз болон тухайн орон нутагтаа Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио, кабелийн сувгийг дамжуулна.

- 9.4 Монгол Улсын нутаг дэвсгэрт орон даяар дамжуулах бол зөвхөн Монгол улсын нутаг дэвсгэрт орон даяар тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийг дамжуулна.
- 9.5 Гадаадын телевиз, радиогийн сувгийн агуулга нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.
- 9.6 Гадаадын аль нэг улсын телевизийн сувгийн тоо нь нийт гадаадын сувгийн 30 хувиас хэтрэхгүй байна.
- 9.7 Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4 заалтыг үндэслэн Зохицуулах хорооноос ОСДҮЭ болон телевиз, радио хооронд харилцан холболт хийх төлбөрийн зарчмыг дараах байдлаар тогтооно. Үүнд:
 - 9.7.1 ОСДҮЭ болон телевиз, радиогийн харилцан холбогдох төлбөрийн зарчим нь “орлогоо өөрөө авч үлдэх” буюу нэг нэгэндээ аливаа төлбөр төлөхгүй, өөрийн орлогыг авч үлдэх зарчим байна.
 - 9.7.2 Гадаадын телевизийн суваг болон энэхүү журмын 2.1.5-д тодорхойлсон “Кабелийн суваг”-ийг дамжуулахад арилжааны зарчим мөрдөгдөнө.
- 9.8 Тухайн зах зээлд давамгайлалтаар тодорхойлогдсон тохиолдолд харилцаа холбооны салбарын өрсөлдөөний зохицуулалттай холбогдох журмыг дагаж мөрдөнө.
- 9.9 Үйлчилгээний нөхцөл, хүлээх үүрэг хариуцлагын талаар хэрэглэгчидтэй гэрээ байгуулж ажиллана.
- 9.10 ОСДҮЭ нь телевиз, кабелийн сувгийн тусгай зөвшөөрөл эзэмшихгүй бөгөөд дамжуулж байгаа суваг дундуур ямар нэг хэлбэрээр зар сурталчилгаа явуулахгүй байна.
- 9.11 Техник төхөөрөмж нь сүлжээний найдвартай ажиллагаа, олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг хангасан байна.
- 9.12 Телевиз, кабелийн сувагтай Зохицуулах хорооноос тогтоосон зааглах цэгт холбогдоно. Зааглах цэг болон техникийн холболт, чанар, стандартын талаарх харилцааг Зохицуулах хорооноос баталсан журмаар зохицуулна.
- 9.13 Хиймэл дагуулаар Засгийн Газраас тодорхойлсон радио, телевизийг төсвийн дэмжлэгтэйгээр дамжуулахдаа хэрэглэгчдээс үйлчилгээний төлбөр авахгүй.
- 9.14 Радио, телевизийн газрын дахин дамжуулах сүлжээ эзэмшигч нь Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз болон Засгийн газраас орон даяар дамжуулахаар тодорхойлсон радио, телевизийг дахин дамжуулах ба Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийг түүний тусгай зөвшөөрөлд заасан хамрах хүрээнд гэрээний үндсэн дээр дахин дамжуулж болно.

Арав. Ёс зүй

- 10.1 Телевиз, радио, кабелийн суваг нь дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн нэгдсэн дүрэм, түүнийг хэрэгжүүлэх ёс зүйн хороотой байна.
- 10.2 Ёс зүйн хороонд Зохицуулах хороо, радио, телевиз, кабелийн суваг, үзэгч, олон нийт, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулж болно.
- 10.3 Ёс зүйн хороо байгуулах, түүний үйл ажиллагаагаа тогтмолжуулахад Зохицуулах хорооноос дэмжлэг үзүүлнэ.
- 10.4 Ёс зүйн хороо нь өөрийн үйл ажиллагааны болон ёс зүйн дүрмийг олонхиороо батална.
- 10.5 Ёс зүйн дүрмийг Зохицуулах хороонд бүртгүүлж, олон нийтэд ил тод мэдээлж, сурталчилна.

Арван нэг. Хяналт

- 11.1 Зохицуулах хороо энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5.3-д зааснаас бусад заалтуудад хамаарах агуулгын болон техникийн чанарын хяналтыг тусгайлсан журам гарган байнгын хяналт тавих тогтолцоог бий болгох замаар хэрэгжүүлнэ.
- 11.2 Зохицуулах хороо хяналтыг хэрэгжүүлэхдээ дараахь арга хэрэгслийг ашиглана.
 - 11.2.1 мониторинг хийх /байнгын, тодорхой давтамжтайгаар/;
 - 11.2.2 хэрэглэгч, үйлчлэгчийн өргөдөл, гомдлын дагуу шалгалт хийх;
 - 11.2.3 үйлчлэгчдээс шаардлагатай мэдээ, тайлан гаргуулах.
- 11.3 Зохицуулах хороо жил бүр хяналтын үр дүнгийн тайлан гаргаж, олон нийтэд мэдээлнэ.
- 11.4 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5.3 заалтад дурдсан агуулгын хяналтыг холбогдох хуульд заасан хяналтын байгууллагууд хэрэгжүүлнэ.
- 11.5 Хяналтын холбогдох бусад байгууллагын хүсэлтээр Зохицуулах хороо мониторинг хийсэн үр дүнг нотлох баримт болгон гаргаж өгч болно.

Арван хоёр . Гомдол маргаан шийдвэрлэх

- 12.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь өргөдөл, гомдол хүлээж авч, шийдвэрлэх өөрийн журамтай байх ба өргөдөл, гомдол хүлээж авах хаяг, утас зэрэг мэдээллийг ил тод мэдээлнэ.
- 12.2 Гомдол, маргаантай асуудлыг маргалдагч талууд (талууд гэдэгт үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгч эсхүл үйлчилгээ эрхлэгчид хамаарна.) шат шатандаа шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд Зохицуулах хороонд хандаж болно.
- 12.3 Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол, маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

Арван гурав. Хариуцлага

- 13.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу дараахь шаардлагатай арга хэмжээг авна:
 - 13.1.1 зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх;
 - 13.1.2 захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх;
 - 13.1.3 тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах;
 - 13.1.4 тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх;
 - 13.1.5 тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох.
- 13.2 Холбогдох хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 13.1.3-13.1.5 –д заасан арга хэмжээг авна.
- 13.3 Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан шийдвэрийг Зохицуулах хороо тухай бүр холбогдох талууд болон олон нийтэд ил тод мэдээлнэ.

- о о о -